



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/73

Мандалговь

“Мал угаалгын суурин ванн шинээр барих ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн хүрээнд санхүүжих “Мал угаалгын суурин ванн шинээр барих ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Ө.Дугармаа (Зах зээл бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн зохицуулагч)

Гишүүд:

Б.Цэрэнчунт (Иргэний төлөөлөл)

Н.Түвшинжаргал (Иргэний төлөөлөл)

Г.Жавзмаа (Аймгийн засаг Даргын тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Э.Энхжаргал (Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2. Үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Ө.Дугармаа)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай хобогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Э.Энхжаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Л.ДОРЖБАТ



486210307